

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 02 дугаар сарын 09

Дугаар 89

Улаанбаатар хот

Дүүргийн цагаатгах ажлыг удирдан  
зохион байгуулах салбар комиссын  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван зургадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Тогтоол баталсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/69 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны  
02 дугаар сарын 09-ний өдрийн  
арван зургадугаар хуралдааны  
89 дүгээр тогтоолын хавсралт

Дүүргийн цагаатгах ажлыг удирдан зохион  
байгуулах салбар комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Комиссын нарийн бичгийн дарга:	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
Гишүүд:	ЦАУЗБСК-ын ажил хариуцсан хэлтсийн дарга Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Ерөнхий нягтлан бодогч ЦАУЗБСК-ын ажил хариуцсан мэргэжилтэн